



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/479

Арвайхээр

**Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,
шууд гэрээ байгуулах эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 34 дүгээр зүйлийн 34.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 79 дүгээр дүгнэлтийн дагуу Төрийн байгууллагуудын засвар, тоног төхөөрөмж /Өвөрхангай/ ажлын 1 дүгээр багц Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Өвөрхангай, Гучин-Ус сум/ ажлыг 19996000 (арван есөн сая есөн зуун ерэн зургаан мянга) төгрөгөөр Өв тана ХХК, 2 дугаар багц Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Өвөрхангай, Өлзийт сум/ ажлыг 30000000 (гучин сая), 3 дугаар багц Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум/ ажлыг 41000000 (дөчин нэгэн сая) төгрөгөөр Дүүрэн цацрах ХХК-иар тус тус гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.


2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

4. Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй 5 дугаар багц Багийн төвийн барилгын их засвар /Өвөрхангай, Хайрхандулаан сум 5 дугаар багц/ ажлыг хүчингүй болгож шууд гэрээ байгуулсугай.

5. Дээрх хүчингүй болсон багцыг техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэн үнийн харьцуулалт хийж, гэрээ байгуулахыг Хайрхандулаан сумын Засаг дарга (Ч.Ганхуяг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100826